



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Төрийн аудитын байгууллагын 2024 оны
үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний
тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.10 дахь заалт, 29.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн аудитын байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайланг баталсугай.

2.Системчилсэн үнэлгээний тайлан, дүгнэлттэй танилцаж, өөрийн чиг үүрэгт хамаарах асуудалд анхаарч ажиллахыг Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга/захирал, тэргүүлэх аудитор нарт зөвлөсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын удирдлагын газар (Ж.Батсайхан)-т үүрэг болгосугай.



Д.ЗАГДЖАВ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ОРШИЛ	4
1. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ	4
2. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	10
3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ	12
3.1. Төрийн аудитын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хүний нөөцийн талаар:	12
3.2. Албан хаагчдын сургалт, хөгжлийн талаар:	13
4. САНХҮҮ БҮЮУ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ҮНЭЛГЭЭ	15
4.1. Төсвийн төлөвлөлт:	15
4.2. Төсвийн гүйцэтгэл:	15
4.3. Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл	17
4.4. Шилэн дансны хуулийн хэрэгжилт	18
4.5. Худалдан авах ажиллагаа	18
5. ДҮГНЭЛТ	19

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ТБХ	Төсвийн Байнгын хороо
ЭЗБХ	Эдийн засгийн Байнгын хороо
ТББХ	Төрийн байгуулалтын Байнгын хороо
НББХ	Нийгмийн бодлогын Байнгын хороо
АҮБХ	Аж үйлдвэржилтийн Байнгын хороо
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
ГБХНХ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ИНТОСАИ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
IFI	Аудитын дээд байгууллагын олон улсын хөгжлийн санаачилга
АДБ	Аудитын дээд байгууллага
ТАБ	Төрийн аудитын байгууллага
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗББН	Зохион байгуулалтын бүтцийн нэгж
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
ТАГ	Төрийн аудитын газар
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
УШХ	Удирдлагын шуурхай хуралдаан
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
FAS	(Financial audit system) Санхүүгийн тайлангийн аудитын систем
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Хүснэгт

Хүснэгт-1	2024 оны аудитын сэдэв, түүний хэрэгжилт
Хүснэгт-2	2024 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт /тоо, төрлөөр/
Хүснэгт-3	2024 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт /мөнгөн дүн, төрлөөр/
Хүснэгт-4	ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
Хүснэгт-5	ҮАГ-ын ЗББН болон АНТАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
Хүснэгт-6	Үүрэг даалгаврын хэрэгжилт
Хүснэгт-7	Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн бүрэлдэхүүн
Хүснэгт-8	Төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг мэргэжил
Хүснэгт-9	Төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг ажилласан жил
Хүснэгт-10	Төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг насны ангилал
Хүснэгт-11	ТАБ-ын нэгдсэн сургалтын хэлбэр, түүний хэрэгжилт
Хүснэгт-12	Төсвийн гүйцэтгэлийн шинжилгээ
Хүснэгт-13	Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

ОРШИЛ

Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилтыг “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах” гэж тодорхойлон баталсан. Дэвшүүлсэн зорилттой уялдуулан ТАБ-ын 2024 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөг 2023 оны А/162, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг (шинэчлэн) 2024 оны А/62 дугаар тушаалаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоол, Хууль зүйн яамнаас боловсруулан гаргасан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Төрийн аудитын байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээг дараах хүрээнд хийлээ. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын чиг үүргийн хэрэгжилт
- Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ
- Санхүү буюу захиргааны зардлын үнэлгээ

Системчилсэн үнэлгээнд Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн тайлан, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн судалгаа, сургалт, хөгжлийн үйл ажиллагааны тайлан, судалгаа, УИХ-ын ТБХ-ны тогтоолоор баталсан аудитын сэдвийн дагуу 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аудитын гүйцэтгэл, үр дүн, 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан болон бусад холбогдох баримт материалыг хамруулж, системчилсэн үнэлгээ хийх арга зүйг ашиглав.

1. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагаас 2024 онд хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх 28, бодлогоор гүйцэтгэх 5, нийт 33 аудитын сэдэв баталсан байна.

Мөн МУЕА-ын 2023 оны А/100 дугаар тушаалаар АНТАГ-ын 2024 онд бодлогоор гүйцэтгэх нийт 15 аудитын сэдэв, А/147, А/150, А/162 дугаар тушаалаар 5 сэдэв баталсны дагуу аудит хийж, аудитын тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Нийт 53 аудитын сэдвээс 52 аудит хийсэн байна. “Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл” сэдэвт аудитын хувьд тайлагналын үе шат 84.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт 37 гадаад оронд суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад аудит хийснээс 31 аудит буюу 84.0 хувь нь төлөвлөсөн хугацаанд, 6 аудит буюу 16.0 хувь нь тайлагналын үе шатанд он дамжсан байна.

Дараах хүснэгтээр УИХ-ын ТБХ-ны тогтоолоор баталсан 33 сэдвийн дагуу хийсэн аудитын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг харуулав.

Хүснэгт-1. 2024 оны аудитын сэдэв, түүний хэрэгжилт

д/д	Аудитын сэдэв (УИХ-ын ТБХ-ны 2023 оны 08 дугаар тогтоол)		Гүйцэтгэл	Хэрэгжсэн эсэх
	Сэдэв	хугацаа		
Нэг. Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх аудитын сэдэв				
1	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	2024.04.14 2024.06.10	Аудитын тайланг МҮЕА-ын 2024 оны А/45, А/46 дугаар дугаар тушаалаар баталгаажуулж, УИХ-ын ТБХ-нд хүргүүлж, УИХ, Байнгын хороодоор хэлэлцүүлж УИХ-ын 2024.08.30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор баталгаажуулсан.	Бүрэн хэрэгжсэн
2	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	2024.03.24 2024.04.25	Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан хуулийн хугацаанд Төсвийн 61 ерөнхийлөн захирагчдын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд MNS 6817, АОУС, ТАБ-ын аудит хийх журам, заавар аргачлалын дагуу аудит хийж, өөрчлөлтгүй 35, хязгаарлалттай 26 дүгнэлт өгч, ТЕЗ нарт хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
3	Сангийн Яамны 2023 оны санхүүгийн тайланд аудит хийх	2024.04.17 2024.05.05	Аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэж, "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгч аудитын тайланг МҮЕА-ын 2024.05.06-ны 1219 дүгээр албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
4	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх	2024.02.27 2024.03.25	Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасан хуулийн хугацаанд төсвийн 369 төвлөрүүлэн захирагчдын 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж, өөрчлөлтгүй 288, хязгаарлалттай 81 дүгнэлт өгч, ТТЗ нарт хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
5	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	2024.01.02 2024.02.25	Засгийн газрын 39 тусгай санд дүгнэлт гаргаж, 26 санд өөрчлөлтгүй, 13 санд хязгаарлалттай дүгнэлтийг тус тус гаргаж, шалгагдагч байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
6	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	2024.02.15 2024.03.15	Төрийн болон орон нутгийн өмчит 584 аж ахуйн нэгжээс 366 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 218 байгууллагын санхүүгийн тайланг үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 3 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Аудитаар 260 байгууллагад өөрчлөлтгүй, 90 байгууллагад хязгаарлалттай, 10 байгууллагад сөрөг дүгнэлтийг тус тус гаргаж, шалгагдагч байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн. 6 байгууллагад дүгнэлт гаргахаас татгалзсан байна.	Бүрэн хэрэгжсэн
7	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	2024.01.02 2024.02.25	Монгол Улсад гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй 112 төсөл, хөтөлбөрийн нэгжээс 55 нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 57 нэгжийн санхүүгийн тайланг үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн байна. Аудитаар 47 нэгжид өөрчлөлтгүй, 8 нэгжид хязгаарлалттай дүгнэлтийг тус тус гаргаж, төсөл, хөтөлбөрийн нэгжийн удирдлагад хүргүүлжээ.	Бүрэн хэрэгжсэн
8	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	2024.01.02 2024.02.25	Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасан хугацаанд 5,444 төсвийн шууд захирагчдын 2,647 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 2,797 байгууллагын санхүүгийн тайланг үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн байна. Аудитаар 2,305 байгууллагад өөрчлөлтгүй, 316 байгууллагад хязгаарлалттай, 16 байгууллагад сөрөг дүгнэлтийг тус тус гаргаж, 10 байгууллагад дүгнэлт гаргахаас татгалзсан байна.	Бүрэн хэрэгжсэн

9	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх.	2024.01.16 2024.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2024 оны А/116 дугаар тушаалаар баталгаажуулж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороодод тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
10	Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх.	2024.01.16 2024.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2024 оны А/117 дугаар тушаалаар баталгаажуулж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох байнгын хороодод тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
11	Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2024.07.15 2024.11.10	37 гадаад оронд суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад аудитыг гүйцэтгэснээс 6 ДТГ-ын аудит тайлагналын үе шатанд, 31 ДТГ-г хийсэн аудитаар өөрчлөлтгүй 16, хязгаарлалттай 15 дүгнэлт өгсөн. Гадаад харилцааны яаманд 2024.09.20-ны өдрийн 07/1894 дүгээр албан бичгээр 11 аудитын тайлан, 2024.12.04-ний 07/2303 дугаар албан бичгээр 11 аудитын тайланг тус тус хүргүүлсэн.	84.0 хувийн гүйцэтгэлтэй
12	Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан харангийн зарцуулалт	2024.02.05 2024.07.01	Тус аудитын тайланг МУЕА-ын тушаалаар баталгаажуулж, УИХ-ын Тусгай хяналтын дэд хороонд 2024.10.28-ны өдрийн мн/42 тоот албан бичгээр хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
13	Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	2024.08.25 2024.10.15	Аудитын тайлан, дүгнэлтийг 2024.12.05-ны 2306 дугаар албан бичгээр УИХ, ЗГ-г хүргүүлж, УИХ-ын 2024.12.12-ны өдрийн чуулганаар эцэслэн баталсан.	Бүрэн хэрэгжсэн
14	Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн	2024.01.05 2024.03.15	Аудитын тайланг МУЕА-ын 2024 оны А/21 дүгээр тушаалаар баталгаажуулж, ТБХ, ЭЗБХ, ЗГХЭГ, ТББХ, ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хэлэлцүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
15	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	2024.01.01 2024.06.10	Аудитын тайланг МУЕА-ын 2024.06.07-ны өдрийн А/45 дугаар тушаалаар баталгаажуулж УИХ-ын ТБХ-д МУЕА-ын 2024.06.07-ны өдрийн 1468 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
16	Улсын төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт	2024.01.16 2024.12.15	ЭЗХЯ-наас Концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийлгэх тухай хүсэлт 2024 онд ирүүлээгүй.	-
17	Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн тухай хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах.	2024.01.16 2024.12.15	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийх аудитаар Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах ажлыг хамруулан үзэж аудитын дүн дүгнэлтэд оруулан тайлагнасан.	Бүрэн хэрэгжсэн

18	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль	Нийт 966 нэр дэвшигчийн данс бүртгэх тухай мэдээллийг 2024.06.04-ний өдөр audit.mn цахим хуудсаар мэдээлж, хуульд заасан хугацаанд бүртгэн 2024.06.17-ны өдөр олон нийтэд, мөн санал авахаас 3 хоногийн өмнө нам, эвсэл, нэр дэвшигчийн хандивын болон зардлын явцын тайланг хүлээн авч 2024.06.26-ны өдөр байгууллагын цахим хуудаст мэдээлсэн.	Бүрэн хэрэгжсэн
19	УИХ-ын ээлжит сонгуулийн жилийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 38 дугаар зүйлийн 38.10-т заасан хугацаанд Сонгуулийн Ерөнхий Хороонд Нам, эвслийн хандивын тайлангийн дүгнэлт, мөн бие даан нэр дэвшигчийн хандивын тайланг нэр дэвшигч нарт хүлээлгэн өгч ажилласан байна. Нам, эвслийн хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2024.06.14-ний өдөр олон нийтэд мэдээлсэн.	Бүрэн хэрэгжсэн
20	УИХ-ын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль	Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, аудитын дүгнэлтийг 2024.06.10-ны өдөр олон нийтэд мэдээлсэн.	Бүрэн хэрэгжсэн
21	УИХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг тогтоох	МУИХ-ын сонгуулийн хууль	Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хугацаанд тогтоож, 2024.02.29-ны өдөр олон нийтэд мэдээлсэн.	Бүрэн хэрэгжсэн
22	УИХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, гишүүнд нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, үр дүнг олон нийтэд мэдээлэх	МУИХ-ын сонгуулийн хууль	Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлснийг хянаж нэгтгэн, дүнгийн тайланг 2024.09.26-ны өдөр олон нийтэд мэдээлсэн	Бүрэн хэрэгжсэн
23	Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох	АНСД-ийн ИТХ-ын сонгуулийн хууль	Нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчдээс аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд 2024.06.25-06.29-ний өдөр олон нийтэд мэдээлсэн.	Бүрэн хэрэгжсэн
24	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх	АНСД-ийн ИТХ-ын сонгуулийн хууль	АНСДИТХСТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.3-д заасны дагуу нам, нэр дэвшигчдийн зардлын дансны мэдээлэл, 56 дугаар зүйлийн 56.3-д заасны дагуу нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хүлээн авч 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар зардлын тайланг баталгаажуулах аудитыг гүйцэтгэсэн. Аудитын тайланг баталгаажуулан 2024.12.30-ны өдрийн дотор аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
25	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах	АНСД-ийн ИТХ-ын сонгуулийн хууль	Орон нутгийн сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд аудит хийж, аудитын дүгнэлтийг 2024.09.18-09.25-ны өдөр олон нийтэд мэдээлсэн.	Бүрэн хэрэгжсэн
26	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах	АНСД-ийн ИТХ-ын сонгуулийн хууль	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, аудитын дүгнэлтийг 2024.09.18-09.25-ны өдөр олон нийтэд мэдээлсэн	Бүрэн хэрэгжсэн

27	Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах	АНСД-ийн ИТХ-ын сонгуулийн хууль	Орон нутгийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэгт заасны дагуу дүгнэлт гаргаж тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
28	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх	2024.01.02 2024.03.15	Аудитын тайланг 2024.03.15-ны өдрийн 682 дугаар албан бичгээр УИХ-ын ТБХ болон ЗГХЭГ, ЗГХЭГ, Шадар сайд зэрэг 24 ТЕЗ болон холбогдох агентлагт тус тус хүргүүлсэн. 2024.03.20-ны өдөр УИХ-ын ТББХ, ЭЗБХ-ны хуралдаанаар аудитын тайланг хэлэлцүүлж улмаар УИХ-ын 2024.03.21-22-ны өдөр Нэгдсэн чуулганаар аудитын тайланг хэлэлцүүлсэн	Бүрэн хэрэгжсэн
Хоёр. Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв				
1	Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө	2024.08.01 2024.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2024.12.12-ны өдрийн А/97 дугаар тушаалаар баталгаажуулж, УИХ-ын ТБХ-нд 2024.12.16-ны өдрийн 2398, ТББХ-нд 2397, ТАЗ-д 2399, ЗГХЭГ-т 2400 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
2	Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө	2024.08.01 2024.11.15	Аудитын тайланг МУЕА-ын 2024.11.15-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар баталгаажуулж, тайланг 2024.11.15-ны өдөр УИХ-ын ТБХ-нд МУЕА-ын 2180, НББХ МУЕА-ын 2181, ГБХНХ-ын сайдад МУЕА-ын 2182, ЭМ-ийн сайдад МУЕА-ын 2179, ЭМДЕГ-т ГНАГ-ын захирлын 08/2184, НДЕГ-т 08/2183 албан бичгээр тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
3	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт, үр дүн	2024.08.01 2024.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2024.12.13-ны өдрийн А/100 дугаар тушаалаар баталгаажуулж, тайланг шалгагдагч болон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
4	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн	2024.08.01 2024.12.15	Аудитыг тайланг МУЕА-ын 2024.12.12-ны өдрийн А/96 дугаар тушаалаар тайланг баталгаажуулж, УИХ-ын ТБХ болон АҮБХ-нд 2024.12.12-ны өдрийн 23/66, 23/67 дугаар, АҮЭБЯ-д 23/68, ҮГА-нд 08/264 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн
5	Монгол Улсын Засгийн газраас хог хаягдлын талаар баримталж буй үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөө	2024.08.01 2024.12.15	Аудитын тайланг МУЕА-ын 2024.12.13-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар баталгаажуулж, тайланг шалгагдагч болон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2024 оны статистик мэдээ, гүйцэтгэлийн тайлан

ТАБ нь 2024 онд нийт 3,823 аудит хийснээс Төрийн аудитын болон Төсвийн тухай хуулиудын дагуу 6,831 төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны санхүүгийн тайланд 3,540 дүгнэлт гаргасан бол 132 гүйцэтгэлийн, 151 нийцлийн аудитаар нийт /давхардсан тоогоор/ 3,604 шалгагдагч этгээд, 8,257 байгууллагыг аудитад хамруулсан байна.

ТАБ-ын 2024 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 46,365.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн нь өмнөх оны илрүүлэлттэй харьцуулахад 21,926.1 тэрбум төгрөгөөр илүү байна. Үүнээс аудитын явцад 5,109.3 тэрбум төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 41,256.1 тэрбум төгрөгийн зөрчлөөс 76.3 тэрбум төгрөгийн зөрчилд 2,418 төлбөрийн акт тогтоож, 33,319.7 тэрбум төгрөгийн зөрчилд 6,389 албан шаардлагыг шалгагдагч этгээдэд хүргүүлж, 7,355.6 тэрбум төгрөгийн зөрчилд 9,629 зөвлөмж, 475.2 тэрбум төгрөгийн зөрчилд холбоотой

315 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 29.3 тэрбум төгрөгийн зөрчилтэй холбоотой 27 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн залруулагдаагүй нийт 41,256.1 тэрбум төгрөгийн зөрчлийн 56.2 хувь буюу 23,188.8 тэрбум төгрөгийг санхүүгийн тайлангийн аудитаар, 41.4 хувь буюу 17,071.2 тэрбум төгрөгийг гүйцэтгэлийн аудитаар, 2.4 хувь буюу 6,105.4 тэрбум төгрөгийг нийцлийн аудитаар тус тус илрүүлсэн байна.

Тайлант онд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын хэрэгжилтийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-2. 2024 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт /тоо, төрлөөр/

Зөрчлийн төрөл	Тайлант он			Үлдэгдэл /Тоо/
	Илрүүлэлт /Тоо/	Хэрэгжилт /Тоо/	Хэрэгжилт хувь	
Зөвлөмж	9,629	7,245	75.24%	2,384
Төлбөрийн акт	2,418	2,136	88.34%	282
Албан шаардлага	6,389	4,723	73.92%	1,666
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	315	257	81.58%	58
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	27	-	-	27
Нийт	18,778	14,361	76.44%	4,417

Хүснэгт-3. 2024 оны аудитын шийдвэр, түүний хэрэгжилт /мөнгөн дүн, төрлөөр/

Зөрчлийн төрөл	Тайлант он			Статистик мэдээнээс хасагдсан /тэрбум төгрөг/	Үлдэгдэл /тэрбум төгрөг/
	Илрүүлэлт /тэрбум төгрөг/	Хэрэгжилт /тэрбум төгрөг/	Хэрэгжилт хувь		
Зөвлөмж	7,355.6	880.7	11.97%	-	6,474.9
Төлбөрийн акт	76.3	11.9	15.59%	-	64.4
Албан шаардлага	33,319.7	1,365.8	4.10%	-	31,953.8
Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	475.2	88.3	18.58%	-	386.9
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	29.3	-	-	-	29.3
Нийт	41,256.1	2,346.7	5.69%	-	38,909.4

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2024 оны статистик мэдээ

Аудитаар илрүүлсэн зөрчилд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт нь барагдуулах болон хэрэгжүүлэхээр тогтоосон хугацаанаас хамааран он дамжин үргэлжилдэг. Үүнээс шалтгаалан аудитын шийдвэрийн хэрэгжилт тоон үзүүлэлтээр авч үзэхэд дунджаар 76.4 хувьтай, мөнгөн дүнгээр тооцоход дунджаар 5.7 хувьтай байна.

Төлбөрийн актын мөнгөн дүн өмнөх оноос 68.5 хувиар буурч, албан шаардлагын мөнгөн дүн 81.0 хувиар нэмэгдэж, зөвлөмжийн тоо 3.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын байгууллага нь Улсын Их Хурал, Засгийн газарт улс орны ирээдүйн хөгжлийг хангах алсын хараатай, зөв шийдвэрийг гаргахад дэмжлэг үзүүлэх, төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалсан үр нөлөө бүхий аудитыг гүйцэтгэх, харилцагч талуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, үр дүнг олон нийтэд сурталчлан таниулж, аудитын үр дүнд бий болох үр өгөөжийг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн 2024 онд “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах” зорилтыг дэвшүүлэн ажилласан. УИХ-аас 2023 оны 07 дугаар сарын 07-нд Төрийн аудитын тухай

хуулийн 20 дугаар зүйлд 20.5¹ дахь заалтыг нэмж, 42 дугаар зүйлийн 42.2² дахь заалтад өөрчлөлт оруулж баталсан нь ТАБ-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт болон шалгагдагч этгээдийн хариуцлагыг дээшлүүлэхэд чухал ач холбогдол болсон байна.

Аудитын үр өгөөжийн талаар:

ТАБ нь 2024 онд гүйцэтгэсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн зөвлөмж, албан шаардлага, аудитын явцад хийсэн залруулгын дүнд шалгагдагч байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөрөнгө, нөөцөө хэмнэх, үр ашгаа дээшлүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чанарыг сайжруулах, төсвийн үр ашгийг бий болгох зэрэг нийт 1,730.5 тэрбум төгрөгийн санхүүгийн, 1,053 санхүүгийн бус үр өгөөжийг (*мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх боломжгүй*) тус тус хүлээн зөвшөөрүүлж бий болгожээ. Улсын төсвөөс авсан 1 төгрөгийн санхүүжилт тутамд 41.3 төгрөгийн үр өгөөжтэй ажиллаж, өмнөх оноос 7.02 хувь буюу 2.9 төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна.

Үндэсний аудитын газар нь Төрийн аудитын байгууллагын манлайллыг нэмэгдүүлэх, менежментийн тогтолцооны чанарын удирдлагыг төлөвшүүлэх, үйл ажиллагааны бүх түвшинд байнгын сайжруулалт хийх зорилгоор 2023 оноос эхлэн Чанарын менежментийн тогтолцоо, ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, 2024 оны 11 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд "Монсертф" ХХК-аас хэрэгжүүлсэн магадлан баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдаж, "Үл тохиролгүй" үнэлгээ авлаа.

2. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/62 дугаар тушаалаар "ТАБ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г шинэчлэн 3 бүлэг 17 зорилтын хүрээнд 138 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталж, 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр **88.08** хувийн биелэлттэй гарчээ. Үүнд:

Хүснэгт-4. ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

д/д	Зорилт	Гүйцэтгэлийн зорилт	Нийт арга хэмжээ	Эзлэх хувь	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					
					Үнэлгээ	100	80.0	50.0	0.0	Үнэ Лээ гүй
1	Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	7	74	53.6%	93.48	57	12	4	-	1
2	Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	5	25	18.1%	86.51	17	3	5	-	-
3	Үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах сайжруулах зорилт	5	39	28.3%	78.76	21	9	4	4	1
Нийт		17	138	100%	88.08	95	24	13	4	2

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

- "бүрэн хэрэгжсэн" – (90.0-100.0) – 95 арга хэмжээ
- "хэрэгжих шатанд" – (70.0-89.0) – 24 арга хэмжээ
- "хэрэгжилт хангалтгүй" – (50.0-65.0) – 13 арга хэмжээ

1 Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

2 Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

- “хэрэгжээгүй” – (0.0) – 4 арга хэмжээ
- “Үнэлээгүй” – 2 арга хэмжээ байна.

ТАБ-ын зохион байгуулалтын бүтцийн 30 нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 1,314 арга хэмжээг тусган хэрэгжүүлжээ. 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр ҮАГ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дундаж үнэлгээ **87.37**, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дундаж үнэлгээ **95.62** хувьтай гарсан байна. Үүнээс:

- “бүрэн хэрэгжсэн” – 883 арга хэмжээ (67.20 хувь)
- “хэрэгжих шатанд” – 245 арга хэмжээ (18.64 хувь)
- “хэрэгжилт хангалтгүй” – 22 арга хэмжээ (1.67 хувь)
- “хэрэгжээгүй” – 4 арга хэмжээ (0.30 хувь)
- “үнэлээгүй” – 160 арга хэмжээ тус тус эзэлж байна.

ҮАГ-ын ЗББН болон АНТАГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт-5. ҮАГ-ын ЗББН болон АНТАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

д/д	ЗББН	Нэгж	Үнэлгээ
1	Санхүү, нийцлийн аудитын газар, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, Дархан-Уул, Баянхонгор, Хэнтий, Сэлэнгэ, Завхан, Хөвсгөл, Архангай, Увс, Өвөрхангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Ховд, Дорнод, Өмнөговь аймаг, Нийслэл дэх ТАГ	17	95.33-98.24
2	Тамгын газар, Баян-Өлгий, Сүхбаатар, Дорноговь, Орхон, Төв, Булган, Дундговь аймаг дахь ТАГ	8	90.07-94.90
3	Чанарын удирдлагын газар, Эрсдэлийн удирдлагын газар, Мэдээлэл, технологийн нэгдсэн төв	3	84.82-87.09
4	Стратеги, төлөвлөлтийн газар, Дотоод аудитын газар	2	78.87-79.06

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

ТАБ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд 2024 онд дараах 3 чиглэлээр нийт 256 үүрэг даалгавар өгөгдөж, хэрэгжилтийн дундаж үнэлгээ **94.19** хувьтай гарсан байна. Үүнд:

Хүснэгт-6. Үүрэг даалгаврын хэрэгжилт

д/д	Үүрэг даалгаврын төрөл	Шийдвэрийн тоо /Тушаал, хурал/		Үүрэг даалгаврын тоо	Үнэлгээ
		Нийт	Үүнээс: Хяналтад авсан		
1	МУЕА-ын “А” тушаал /2023 оны 18, 2024 оны 94 тушаалаас хяналтад 52 тушаал авсан/	52	Хяналтад авсан 52 тушаалын нийт 134 заалт	134	95.98
2	Удирдах ажилтны зөвлөгөөн	1 зөвлөгөөн		5	96.32
3	Удирдлагын шуурхай хуралдаан	Тайлант хугацааны УШХ - 16, 2023 оны УШХ(18, 19) – 2, АНТАГ-ын УШХ – 6 Нийт 24 хурлаас нийт 117 үүрэг даалгавар		117	90.28

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

3.1. Төрийн аудитын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хүний нөөцийн талаар:

МУЕА-ын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/51 дүгээр тушаалын дагуу нийт 579 орон тоотой ажиллахаас 2024 онд 508 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд хууль тогтоомж, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, төрийн албан хаагчийн шатлан дэвших зарчмыг баримтлан Төрийн аудитын байгууллага дотроо албан тушаал дэвшүүлэн томилсон болон бүтцийн нэгж дотроо ижил ангиллын албан тушаалд шилжүүлэн томилсон 37, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн томилсон 13, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөөс томилсон 115, нийт 152 иргэн, албан хаагчийг томилсон байна. Мөн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 24, өндөр насны тэтгэвэрт гарсан 12, байгууллага хооронд шилжсэн 9 албан хаагчийг тус тус чөлөөлсөн байна.

ТАБ-ын удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 6 удаа зохион байгуулж, шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн 169 иргэн, албан хаагчаас шалгалт авч, тэнцсэн 99 албан хаагчдыг албан тушаалд нэр дэвшүүлэн томилжээ.

Хүснэгт-7. Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн бүрэлдэхүүнийг авч үзвэл:

Байгууллага, нэгж	Нийт албан хаагч		Аудитын чиг үүрэг хэрэгжүүлдэг		Захиргаа, бусад чиг үүрэг хэрэгжүүлдэг	
	579		467 (80.7%)		112 (19.3%)	
ҮАГ	194	33.5%	131	28.0%	63	56.3%
Нийслэл дэх ТАГ	61	10.5%	54	11.6%	7	6.2%
Аймаг дахь ТАГ	324	56.0%	282	60.4%	42	37.5%

Хүснэгт-8. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг мэргэжлийн хувьд авч үзвэл:

Байгууллага, нэгж	Нийт	Нягтлан бодогч, эдийн засагч		Эрх зүйч		Инженер		Бусад	
		508	360	70.87%	55	10.83%	28	5.50%	65
ҮАГ	186	100		30		21		35	
Нийслэл дэх ТАГ	56	36		10		4		6	
Аймаг дахь ТАГ	266	224		15		3		24	

Хүснэгт-9. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын төрд ажилласан жилийн хувьд авч үзвэл:

Байгууллага, нэгж	Нийт	0-5 жил		6-10 жил		11-15 жил		16-аас дээш жил	
		508	153	30.1%	110	21.7%	97	19.1%	148
ҮАГ	186	39		36		27		84	
Нийслэл дэх ТАГ	56	11		11		8		26	
Аймаг дахь ТАГ	266	103		63		62		38	

Хүснэгт-10. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг насны ангиллаар авч үзвэл:

Байгууллага, нэгж	Нийт	30 хүртэлх		31-40 нас		41-50 нас		50-60 нас	
		508	50	9.8%	178	35.0%	171	33.7%	109
ҮАГ	186	30		64		54		38	
Нийслэл дэх ТАГ	56	2		19		17		18	
Аймаг дахь ТАГ	266	18		95		100		53	

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын 2024 оны статистик мэдээ

Нийт албан хаагчдын 42.5 хувь буюу 216 эрэгтэй, 57.5 хувь буюу 292 эмэгтэй албан хаагчид эзэлж байна.

ТАБ-ын ажлын ачаалал их, хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан тайлант хугацаанд гүйцэтгэлийн аудитад нийт 24 гэрээт шинжээч, санхүүгийн тайлангийн аудитад 95 аудитын хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллуулсан байна. Орон нутгийн ТАГ-ын түвшинд хүний нөөц хүрэлцээгүй байдагтай холбоотой төрөлжсөн аудитын албаны чиглэлээр ажиллах боломжгүй тул аудиторуд нь бүх төрлийн (*санхүү, гүйцэтгэл, нийцлийн*) аудитад зэрэг оролцож байна. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрсдэлийн удирдлагын газрыг Үндэсний аудитын газарт, Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газарт “шинжээч /нягтлан бодогч, бичиг хэрэг дотоод ажил хариуцсан/”-ийн орон тоог шинээр бий болгосон.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг орон нутагт жигд чанартай хүргэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-д 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20.0-80.0 хувиар олгохоор шийдвэрлэсний дагуу төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож байна.

Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6³-д заасны дагуу УИХ-аас ТАБ-ын албан хаагчдад олгох цалингийн нэмэгдэл, түүний хувь хэмжээг тогтоодог тул орон нутагт ажиллаж байгаа ТАБ-ын албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох хууль, эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалан орон нутаг дахь ТАБ-д ажиллах боловсон хүчин дутагдалтай, ажлын ачаалал их байдаг байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь заалтад орон нутгийн нэмэгдлийг олгох талаар нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байгааг харуулж байна.

ТАБ-ын 2024 оны албан хаагчдын ажлын цагийн бүртгэлээр нийт албан хаагчид аудитын болон дэмжих үйл ажиллагааг явуулахад нийт 67,954 илүү цаг ажилласан байна.

3.2. Албан хаагчдын сургалт, хөгжлийн талаар:

Төрийн аудитын байгууллагын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг дотоод болон гадаад сургалт бүхий 2 бүлэг, 53 төрлийн багц 1,433 цагийн сургалтыг давхардсан тоогоор 7,233 албан хаагчийг хамруулан зохион байгуулахаар төлөвлөж баталсан бөгөөд хэрэгжилтийн хувьд тайлант онд нийт 93 сургалтыг зохион байгуулж, 7,720 албан хаагчийг хамруулсан байна.

Тайлант хугацаанд сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт 93 сургалтын 59 хувь буюу 55 нь дотоод сургалт, 23 хувь буюу 21 нь гадаад сургалт, 18 хувь буюу 17 нь бусад байгууллагатай хамтарсан сургалтыг тус тус зохион байгуулсан байна. Үүнээс 55 дотоодын сургалтын 16 хувийг онлайнгаар (*ZOOM*), 47 хувийг цахимаар (*ТАБ-ын цахим сургалтын систем*), 11 хувийг хосолсон (*онлайн болон танхимаар*) сургалт, 26 хувийг танхимаар зохион байгуулжээ.

³ Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хувь, хэмжээг Улсын Их Хурал тогтооно

Хүснэгт-11. ТАБ-ын нэгдсэн сургалтын хэлбэр, түүний хэрэгжилт

д/д	Сургалтын хэлбэр, төрөл	Зохион байгуулагдсан Сургалтын тоо	Сургалтад Хамрагдсан албан хаагчдын тоо
А	Дотоод сургалт	55	7,156
1	Цахим сургалт (ТАБ-ын цахим сургалтын систем)	26	4,612
1.1	Үндсэн сургалт	21	965
1.2	Хөгжлийн сургалт	5 багц (Нээлтэй бүх сургалт)	3,647
2	Танхимын сургалт	14	567
3	Онлайн сургалт	9	945
4	Хосолсон сургалт (онлайн болон танхимаар)	6	1,032
5	Удирдлагын академи, ММНБИ, бусад	17	490
Б	Гадаад сургалт	21	74
	Нийт	93	7,720

Тайлант хугацаанд шинээр томилогдсон 78 албан хаагчийг “Төрийн аудитын сургалт, хөгжлийн систем”-ийн Хөгжлийн сургалт талбарын Хувь хүний хөгжил цэсэд байршуулсан шинэ ажилтныг чиглүүлэх 1-6 багц сургалтад хамруулжээ. Эдгээр багц сургалтуудад албан хаагчид давхардсан тоогоор 339 удаа хандалт хийж судалсан байна.

ТАБ-ын сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан сургалтаас гадна мөн нийт ЗББН-үүд үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны болон албан хаагчдын хувь хүний хөгжлийг дэмжсэн нийт 549 дотоод сургалтыг зохион байгуулж, нэг ЗББН дунджаар 17 сургалтыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

ТАБ-ын Дотоод сургалтын хувьд 55 сургалтад 7,156 албан хаагчийг хамруулсан. Гадаад сургалтын хувьд ИНТОСАИ-н хөгжлийн санаачилга (IDI)-аас зохион байгуулж буй болон бусад орны Аудитын дээд байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан 21 гадаад сургалт, хөтөлбөр, арга хэмжээнд 74 албан хаагчийг давхардсан тоогоор хамруулсан байна. Мөн бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 17 сургалтад 490 албан хаагч хамрагдсан байна.

МУЕА-ын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/106 дугаар тушаалаар “ТАБ-ын аудитын чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ”-г баталсан. Уг чадамжийн хүрээ нь албан хаагчид өндөр хариуцлагатай байж ажил үүргээ үр дүнтэй биелүүлэхийн тулд мэргэжлийн ур чадвараа тогтмол хөгжүүлэх, бүтээмжээ дээшлүүлэхэд туслах, гүйцэтгэлийг чанартай, өндөр түвшинд хүргэх боломжийг байгууллагад олгох болон байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадваруудыг тодорхойлох, сургалт, хөгжил, төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн залгамж халааны төлөвлөлт, зохион байгуулалт хийхэд чухал баримт бичиг болжээ. Мөн “Нэгдсэн сургалт 2024” сургалтаар чадамжийн хүрээ, түүний менежментийн талаар ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт хийсэн. “ТАБ-ын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ”-г хэрэглэх зөвлөмжийн төслийг боловсруулсан.

Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээг сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж ажиллаж байна.

4. САНХҮҮ БУЮУ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ҮНЭЛГЭЭ

4.1. Төсвийн төлөвлөлт:

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны төсвийн саналаа боловсруулж, хуулийн хугацаанд Сангийн яам болон УИХ-ын Төсвийн байнгын хороонд 42.6 тэрбум төгрөгөөр төсөвлөн хүргүүлснийг 1.2 тэрбум төгрөгөөр бууруулж, 41.4 тэрбум төгрөгөөр баталсан байна.

УИХ-ын 2024 оны 39 дүгээр тогтоолоор ТАБ-ын албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон, мөн Төсвийн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр тогтоолоор орон тооны хязгаар нэмэгдсэн зэрэгтэй уялдуулан УИХ-аас ТАБ-ын төсвийг 2.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 44.3 тэрбум төгрөгөөр баталсан байна.

АДБ-уудын үндсэн хууль хэмээн үздэг Лимагийн тунхаглалын 7 дугаар зүйлийн 1-д “АДБ ажил үүргээ хэрэгжүүлэх боломж олгохуйц санхүүгийн хөрөнгөөр хангагдана”, Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжнэ. Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана” гэж ТАБ-ын санхүүгийн хараат бус, бие даасан байдлыг тодорхойлж өгсөн.

Улмаар уг хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т “Засгийн газар төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж ТАБ-ын гүйцэтгэх засаглалаас хараат бус байх байдлыг хангаж өгсөн байна.

Гэсэн хэдий ч ТАБ нь Сангийн яамнаас төсвийн хувьд бүрэн хараат бус байж чадахгүй байна. Тухайлбал: ТАБ нь жил бүр төсвийн төслөө боловсруулж, УИХ-ын Төсвийн байнгын хороогоор хянагдан, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн боловч 2020 онд 1.4 тэрбум, 2021 онд 2.0 тэрбум, 2022 онд 1.1 тэрбум, 2023 онд 2.6 тэрбум, 2024 онд 1.2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

ТАБ-ын 2024 оны батлагдсан 44.3 тэрбум төгрөгийн төсвийг өмнөх оны төсөвтэй харьцуулахад 15.5 тэрбум төгрөг буюу 53.8 хувиар нэмэгдсэн байна.

4.2. Төсвийн гүйцэтгэл:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн 40.6 хувь буюу 18.0 тэрбум төгрөгийг УАГ-т, 10.4 хувь буюу 4.6 тэрбум төгрөгийг Нийслэл дэх ТАГ-т, 46.9 хувь буюу 20.8 тэрбум төгрөгийг 21 аймаг дахь ТАГ-т, 2.1 хувь буюу 0.9 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад хуваарилан, зарцуулахаар төлөвлөсөн байна.

Батлагдсан төсвийн 28.2 тэрбум төгрөг буюу 63.6 хувийг үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллын зардал, 3.5 тэрбум төгрөг буюу 7.9 хувийг НДШ-ийн зардал, 3.4 тэрбум төгрөг буюу 7.7 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 8.3 тэрбум төгрөг буюу 18.8 хувийг бусад зардал, 0.9 тэрбум төгрөг буюу 2 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

ТАБ-ын хэмжээнд 2024 онд 44.3 тэрбум төгрөгийн зардлыг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 42.7 тэрбум төгрөг зарцуулж, 1.6 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5⁴-д заасан цаглаварт хугацаа болоогүй байгаа тул МУЕА-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд үнэлгээ хийгдээгүй болно.

⁴ төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн

Говь-Алтай аймаг дахь ТАГ-аас бусад ҮАГ, 20 аймаг, нийслэл дэх ТАГ-ууд өөрийн эзэмшлийн ажлын байргүй Засгийн газрын болон орон нутаг дахь төр захиргааны байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Ажлын байрны түрээсийн зардалд 2024 онд Үндэсний аудитын газар 298.2 сая төгрөг, Нийслэл дэх Төрийн аудитын газар 98.8 сая төгрөг, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар 3.9 сая төгрөг, нийт 401.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

ҮАГ-ын хувьд Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан төрийн албан хаагчийн ажлын өрөөний талбайн хэмжээ болон ажлын байр хүрэлцээгүй зэргээс шалтгаалан 4 ЗББН (СТГ, ЧУГ, ДАГ, МТНТ) хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн байранд түрээсийн төлбөр төлж үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10⁵ дахь заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын төсвийн гүйцэтгэлийн талаар:

ҮАГ-ын нийт зардал 2024 онд 18,033.5 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 16,814.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 6.8 хувиар буюу 1,219.5 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 16,814.0 сая төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1,047.9 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 55.8 сая төгрөг, томилолт, зочны зардал 55.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-12. Төсвийн гүйцэтгэлийн шинжилгээ:

Үзүүлэлт	2023 он		2024 он		Өмнөх оноос		Батлагдсан төсвөөс	
	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Дүн /сая.төг/	Хувь	Дүн /сая.төг/	Хувь
Нийт зардлын дүн	13,296.8	13,193.6	18,033.5	16,814.0	3,620.4	27.4	(1,219.5)	(6.8)
Урсгал зардлын дүн	13,296.8	13,193.6	17,561.0	16,378.2	3,184.6	24.1	(1,182.8)	(6.7)
Цалин хөлс,	7,416.2	7,414.0	10,813.5	10,800.9	3,386.9	45.7	(12.6)	(0.1)
Ажил олгогчоос төлөх НДШ	934.3	934.3	1,351.7	1,351.7	417.4	44.7	-	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235.6	235.6	302.4	298.2	62.6	26.6	(4.2)	(1.4)
Хангамж, бараа материалын зардал	147.3	147.3	208.4	203.3	56.0	38.0	(5.1)	(2.4)
Эд хогшил, урсгал засварын зардал	149.9	149.9	410.0	354.1	204.2	136.2	(55.9)	(13.6)
Томилолт, зочны зардал	150.3	150.3	1,148.5	1,093.2	942.9	627.3	(55.3)	(4.8)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	2,612.4	2,612.2	3,066.4	2,018.6	(593.6)	(22.7)	(1,047.8)	(34.2)
Бараа үйлчилгээний бусад зардал	57.1	57.1	260.0	258.3	201.2	352.4	(1.7)	(0.7)
Урсгал шилжүүлэг	1,593.7	1,492.9	472.6	435.7	(1,057.2)	(70.8)	(36.9)	(7.8)
Хөрөнгийн зардал	-	-	-	-	-	-	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	13,296.8	13,193.6	18,033.5	16,814.0	3,620.4	27.4	(1,219.5)	(6.8)
Улсын төсвөөс санхүүжих	13,296.8	13,193.6	18,033.5	16,814.0	3,620.4	27.4	(1,219.5)	(6.8)

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

⁵ Төрийн аудитын дээд байгууллагын байр төрийн хамгаалалтад байна.

Нийт зардлын 72.3 хувийг ажиллагсдын цалин хөлс болон НДШ-ийн зардалд, 12.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 6.5 хувийг томилолт, зочны зардалд, 2.6 хувийг бусад урсгал шилжүүлэгт, 1.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 2.1 хувийг эд хогшил, урсгал засварын зардалд, 1.2 хувийг хангамж, бараа материалын зардалд, 1.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.

4.3. Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл

ҮАГ-ын 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1⁶-д заасан цаглаварт хугацаанд гаргаж, УИХ-ын даргын захирамжаар томилогдсон “Ди Эй Би Жи аудит” ХХК-иар санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлгэж, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,076.5 сая төгрөгөөр буюу 27.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 13. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт:

д/д	Балансын зүйл	2023 он		2024 он		Өмнө онтой харьцуулахад	
		Дүн /сая.төг/	Нийт хөрөнгийн дүнд эзлэх хувь	Дүн /сая.төг/	Нийт хөрөнгийн дүнд эзлэх хувь	Дүн /сая.төг/	Хувь
1.	Мөнгөн хөрөнгө	189.0	4.8	191.0	3.8	2.0	1.1
2.	Авлага	1,090.4	27.6	1,158.4	23.0	68.0	6.2
3.	Урьдчилгаа	8.7	0.2	74.4	1.5	65.7	755.2
4.	Бараа материал	457.7	11.6	1,109.1	22.0	651.4	142.3
5.	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,745.8	44.1	2,532.9	50.3	787.1	45.1
6.	Биет хөрөнгө	2,040.5	51.6	2,390.2	47.5	349.7	17.1
7.	Биет бус хөрөнгө	168.3	4.3	107.9	2.1	(60.4)	(35.9)
8.	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,208.8	55.9	2,498.1	49.7	289.3	13.1
9.	Нийт хөрөнгийн дүн	3,954.6	100.0	5,031.0	100.0	1,076.4	27.2
10.	Богино хугацаат өр төлбөр	956.6	24.2	1,104.2	21.9	147.6	15.4
11.	Өр төлбөрийн дүн	956.6	24.2	1,104.2	21.9	147.6	15.4
12.	Засгийн газрын хувь оролцоо	553.2	14.0	553.2	11.0	-	-
13.	Хуримтлагдсан үр дүн	2,254.2	57.0	3,183.0	63.3	928.8	41.2
14.	Өмнөх үеийн үр дүн	3,675.2	92.9	2,193.4	43.6	(1,481.8)	(40.3)
15.	Тайлант үеийн үр дүн	(1,421.0)	(35.9)	989.6	19.7	2,410.6	169.6
16.	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190.6	4.8	190.6	3.8	-	-
17.	Өр төлбөр ба эзний өмчийн дүн	3,954.6	100.0	5,031.0	100.0	1,076.4	27.2

Эх сурвалж Үндэсний аудитын газрын 2024 оны санхүүгийн тайлан

Дээрх санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад урьдчилгаа, бараа материал, биет бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүн данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан, санхүүгийн тайланд их дүнтэй авлага, бараа материал, богино хугацаат өр төлбөр байна. Их дүнтэй авлага, өглөгийн дансны хувьд санхүүгийн тайлангийн

⁶ төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;

аудитыг гэрээгээр гүйцэтгэж буй аудитын хуулийн этгээдтэй холбоотой авлага, өглөгүүд дийлэнх хувийг эзэлж байна.

ҮАГ-ын Мэдээлэл, технологийн нэгдсэн төвөөс хөгжүүлсэн “FAS” системийн эхний шатны хөгжүүлэлтийг МУЕА-ын 2023 оны А/155 дугаар тушаалаар хүлээн авсан байх тул санхүүгийн тайлангийн аудитад ашиглаж буй тус программ хангамжийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, хөрөнгөөр бүртгэх шаардлагатай байна.

4.4. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1, 3.2-т заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- ҮАГ тайлант хугацаанд байршуулбал зохих нийт 171 мэдээллээс 94.7 хувийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулж, 6 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй;
- ТЕЗ-ын хувьд байршуулбал зохих нийт 144 мэдээллээс 91.7 хувийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулж, 4 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

4.5. Худалдан авах ажиллагаа

ТАБ-ын хэмжээнд тайлант хугацаанд 1,920.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 арга хэмжээ бүхий худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө баталснаас 1,700.2 сая төгрөгийн 10 худалдан авах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж ажилласан байна. Үүнээс:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 881.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй суурин болон зөөврийн компьютер, техник хэрэгсэл худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 763.6 сая төгрөгөөр худалдан авалтыг хийсэн;
- Урсгал төсвөөс нийт 1,039.2 сая төгрөгийн 10 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс 936.5 сая төгрөгийн 9 худалдан авалтыг зохион байгуулсан байна.

ТАБ-ын аудитын бус чиг үүрэг бүхий албан хаагчдын мэргэжлийн чадамжийн хүрээг тодорхойлох, чадамжийн үнэлгээ хийх, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах тендерийг 3 удаа зохион байгуулсан боловч тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендер ирээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна.

5. ДҮГНЭЛТ

Системчилсэн үнэлгээний явцад цуглуулсан нотлох зүйл, үнэлгээний дүнд үндэслэн Төрийн аудитын байгууллагын 2024 оны үйл ажиллагааг дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

- ТАБ нь УИХ-ын ТБХ-ны тогтоол болон МУЕА-ын тушаалаар баталсан 2024 онд гүйцэтгэх аудитын сэдвийн хүрээнд 53 аудитыг гүйцэтгэснээс 52 аудит буюу 98.1 хувийг бүрэн хэрэгжүүлж, аудитын тайланг УИХ-ын холбогдох Байнгын хороод, шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн, 1 аудит тайлагналын үе шатанд он дамжин 84.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх онтой харьцуулахад хэрэгжилт 12.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- ТАБ нь 2024 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 46,365.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн нь өмнөх оны илрүүлэлттэй харьцуулахад 21,926.1 тэрбум төгрөгөөр илүү байна. Аудитын илрүүлэлтийн хувь 2022 онд өмнөх оноос 33.6 хувиар, 2023 онд өмнөх оноос 81.3 хувиар, 2024 онд өмнөх оноос 47.2 хувиар тус тус тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. Илрүүлэлтийн хувь тасралтгүй өсөж буй нь аудитын үйл ажиллагаа илүү үр дүнтэй, чанартай болж байгааг илтгэж байна.
- ТАБ нь 2024 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 1,730.5 тэрбум төгрөгийн санхүүгийн, 1,053 санхүүгийн бус үр өгөөжийг (*мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх боломжгүй*) тус тус хүлээн зөвшөөрүүлж бий болгожээ. Улсын төсвөөс авсан 1 төгрөгийн санхүүжилт тутамд 41.3 төгрөгийн үр өгөөжтэй ажиллаж, өмнөх оноос 7.02 хувь буюу 2.9 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь аудитын үйл ажиллагааны нийгэмд үзүүлж буй бодит санхүүгийн хувь нэмрийг харуулж байна.
- ТАБ нь 2023-2024 онуудад “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах” зорилтыг дэвшүүлэн ажилласан. Төрийн аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийн хувь нь 2021-2023 онуудад тогтвортой өссөн үзүүлэлттэй байсан бол 2024 оны байдлаар аудитын шийдвэрийн хэрэгжилт 76.4 хувьтай, мөнгөн дүнгээр тооцоход дунджаар 5.7 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 4.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- ТАБ нь 2024 онд “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах” зорилтыг дэвшүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 17 зорилтын хүрээнд 138 арга хэмжээг төлөвлөн, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжилт 88.08 хувьтай үнэлэгдсэн байна. ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Бүрэн хэрэгжсэн” арга хэмжээний тоо жилээс жилд өсч, хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээний тоо жилээс жилд буурсан үзүүлэлттэй байгаа нь ТАБ-ын бодлого, төлөвлөлт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө нэмэгдэж, хариуцлага сайжирч буйг харуулж байна.
- ТАБ-ын албан хаагчдын 70.0 хувь нь 6 ба түүнээс дээш жил төрийн байгууллагад ажилласан, 70.9 хувь нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засагч, 10.8 хувь нь эрх зүйч мэргэжлийн албан хаагч байгаа нь тус байгууллагын хүний нөөцийн тогтвор суурьшил, мэргэшсэн байдал, залгамж чанарыг хадгалах зарчмыг хэрэгжүүлж буйг харуулж байна.
- ТАБ нь сургалтын цахим системийг тогтвортой хөгжүүлэн, 2024 онд 2 бүлэг, 53 төрлийн багц 1,433 цагийн сургалтыг давхардсан тоогоор 7,233 албан хаагчийг хамруулахаар төлөвлөж, тайлант онд нийт 93 сургалтыг зохион байгуулж, 7,720 албан хаагчийг хамруулсан нь хүний нөөцийг сургаж хөгжүүлэх, чадавхыг сайжруулахад чухал хувь нэмэр оруулж байна.
- Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т “Засгийн газар Төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж Улсын Их

Хуралд өргөн мэдүүлнэ” гэж гүйцэтгэх засаглалаас төсөв, санхүүгийн хувьд хараат бус байх зохицуулалтыг хэрэгжүүлэх чиглэлд УИХ, ЗГ-тай хамтран ажиллах шаардлага байна.

- Дэлхийн Аудитын дээд байгууллагын⁷ гүйцэтгэлийн төлөв байдлын 2023 оны тайлангийн үр дүнгээс харахад дэлхий даяар хариуцлага, ардчилал буурах чиг хандлагатай байгаа нь Аудитын дээд байгууллагын бие даасан байдалд хөндлөнгөөс оролцох оролцоо нэмэгдэх, хариуцлагатай ажиллах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл байгааг илрүүлж, энэ нь төрийн төсөв санхүүгийн зарцуулалт болон засаглалын асуудалд хариуцлага тооцоход саад болж, ажил үүргээ биелүүлэх боломжийг хязгаарлах магадлалтай талаар дүгнэсэн. Иймээс Аудитын дээд байгууллагууд нь олон улсын стандартуудыг амжилттай нэвтрүүлэн, стратегийн засаглалыг бэхжүүлж, аудитын үйл ажиллагааг улам боловсронгуй болгож, шинээр үүсэж буй сорилтуудад шуурхай хариу арга хэмжээ авч ажиллах шаардлага тулгарч байна. ТАБ нь 2024 онд “Төрийн аудитын байгууллагын 2025-2030 онд хэрэгжүүлэх стратеги”-г олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн баталж, эрсдэлийг удирдах замаар үйл ажиллагаанд тасралтгүй сайжруулалт хийх зорилготой аудитын чанарын зорилт руу чиглэсэн АДБОУС-140 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗАР

⁷ ТАБ-ын сургалтын цахим систем: Дэлхийн Аудитын дээд байгууллагын гүйцэтгэлийн төлөв байдлын 2023 оны тайлан